



**МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр,  
Утас: 26-36-95, Факс: (976-11) 32-35-41, 32-09-16  
И-мэйл: moh@moh.gov.mn, http://www.mohs.mn

2017.03.17 № 101/1070

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Т  
ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН  
ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН  
ТӨВ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗАР, НЭГДСЭН  
ЭМНЭЛГИЙН ДАРГА НАРТ

Г Т  
**Мэдээлэл хүргүүлэх тухай**

“Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд нийлүүлэгдэж буй “e-Health” програм хангамж нь иргэдийн эрүүл мэндийн талаарх нууц мэдээллийг агуулдаг. Тиймээс энэхүү програм хангамжийн нэвтрүүлэлт, сууринуулалтын ажлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (YAB3), Кибер аюулгүй байдлын газар (КАБГ), Эрүүл мэндийн яамны шууд хяналт дор гүйцэтгэж байгаа болно.

Сүүлийн үед хувийн хэвшлийн байгууллага болон төрийн бус байгууллагын зүгээс уг системтэй танилцах нэрийдлээр эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдалд халдаж, иргэдийн мэдээлэлтэй танилцах, улмаар уг системийн талаар олон нийтэд ташаа мэдээлэл түгээх зэрэг зохисгүй үйлдлийг ихээр гаргах боллоо. Мөн 2017 он гарсаар хөрш зэргэлдээх Оросын Холбооны Улсын Эрүүл мэндийн яам кибер халдлагад өртсөн тухай мэдээллийг бид хүлээж аваад байна.

Иймд эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд уг асуудалд анхаарлаа хандуулж, өөрсдийн байгууллагын ажилчдын сахилга батыг дээшлүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, YAB3 болон КАБГ-ын зөвшөөрөлгүйгээр гадны байгууллага, хувь хүнийг иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдээлэлд хандуулахгүй байх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллахыг мэдэгдье.

САЙД   
А.ЦОГЦЭЦЭГ